


**СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ
ХИЙХ ЖУРАМ**

Бүртгэлийн дугаар -	Мөрдөж эхлэх огноо: 2023/08/03	Хувилбарын дугаар – 1.0	Хуудасны тоо - 9
---------------------	-----------------------------------	----------------------------	------------------

“ЛэндМН БСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн
23/24 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Баримтын төрөл:	Журам
Нууцын зэрэглэлтэй эсэх:	Олон нийтэд хүргээжүүлжээ
Зохицуулах үйл ажиллагаа:	Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үед түүнийг хэрхэн хийх зарчмыг тогтоох
Хариуцах нэгж/ ажилтан:	Эрсдэл, хянан нийцүүлэлтийн газар
Тус хувь хүртэх нэгж/ танилцах ажилтан:	Бүх нэгж/ Бүх ажилтнууд

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	3
ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	4
ДӨРӨВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЕРӨНХИЙ ЖУРАМ.....	5
ТАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ.....	5
ЗУРГАА. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛД ТООЦОГДОХГҮЙ НӨХЦӨЛ.....	6
ДОЛОО. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ.....	7
НАЙМ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ.....	7
ЕС. ХАРИУЦЛАГА.....	8
АРАВ. БУСАД.....	8
ХАВСРАЛТ	

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам (цаашид "Журам")-ын зорилго нь "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани") болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх үүднээс сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү Журмыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Компанийн Засаглалын Кодекс, Компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд боловсруулав.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1.1 "Эрх бүхий албан тушаалтан" гэж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ")-ийн дарга болон гишүүд, Компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, бусад захирлууд, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг;
- 2.1.2 "Нэгдмэл сонирхолтой этгээд" гэж Компанийн эрх бүхий албан тушаалтан болон Компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй хамаарал бүхий дор дурдсан этгээдийг:
 - a. Тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;
 - b. Тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;
 - c. Тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанийтай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд;
 - d. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран Компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;
 - e. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлсон Компанийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд Компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
 - f. Компанийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн (бүлэг хүмүүс);
 - g. Нэг хүн (бүлэг хүн) гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани;
 - h. Компани эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан;
 - i. Хэлцлийн нэг тал ажил олгогч бол түүний ажилтан.

- 2.1.3 “Сонирхлын зөрчил бүхий этгээд” гэж Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамtran эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанийтай дор дурдсан харилцаанд орсон бол Компанитай, эсхүл Компанийн хараат болон охин компанийтай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:
- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны (ногдол хувийн) 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамtran эзэмшиж байгаа;
 - Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны (ногдол хувийн) 20 болон түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамtran эзэмшиж байгаа;
 - Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа этгээд.

2.1.4 “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж энэхүү Журмын 2.1.3-т заасан Сонирхлын зөрчил бүхий этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа этгээдтэй хийж байгаа хэлцлийг;

2.1.5 “Их хэмжээний хэлцэл” гэж энэхүү Журмын 7.1-т заасны дагуу тодорхойлогдсон хэлцлийг.

ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1 Сонирхлын зөрчил бүхий этгээд нь Компанийн ТҮЗ-ийн нарийн бичгийн даргад дараах мэдээллийг энэхүү Журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй ба хэрэв тухайн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт орсноос хойш хуанлийн 10 хоногийн дотор дахин мэдээлнэ:
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамtran энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;
 - Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;
 - Компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухай;
 - Энэхүү Журмын 2.1.3-т заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.

- 3.2 Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтлөх бөгөөд сонирхогч этгээд танилцах боломжийг хангаж ажиллана.

ДӨРӨВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

- 4.1 Компани нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийн өмнө уг хэлцлийн талаарх мэдээлэл, хэлцлийн нөгөө тал болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан танилцуулгыг бэлтгэж Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд ирүүлнэ.
- 4.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь танилцуулгыг хүлээн авч хэлэлцэх бөгөөд тухайн хэлцлийн нөхцөл, агуулгыг тодорхойлж, Компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэсэн дүгнэлт гаргана.
- 4.3 Хэрэв Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн нь тухайн хэлцлийн хувьд Сонирхлын зөрчил бүхий этгээдэд тооцогдохоор бол тус гишүүн нь энэхүү Журмын 4.2-т заасан дүгнэлт гаргахад санал өгөх эрхгүй байна.
- 4.4 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүдийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар энэхүү Журмын 4.2-т заасан дүгнэлтийг гаргана.
- 4.5 Хэрэв Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүд тухайн хэлцлийн хувьд бүгд Сонирхлын зөрчил бүхий этгээдэд тооцогдохоор бол энэ тухай дүгнэлтэд тусгаж Компанийн ТУЗ-д хүргүүлэх бөгөөд Компанийн ТУЗ нь тус асуудлыг хурлаар хэлэлцэх эсэхийг энэхүү Журамд заасан зарчмын дагуу жич шийдвэрлэнэ.

ТАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

- 5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар Компанийн сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.
- 5.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.
- 5.3 Энэхүү Журмын 5.1-т заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дараа Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийнэ.
- 5.4 Компани нь дараах тохиолдолд Сонирхлын зөрчилтэй хэлцэл (хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл) хийх, өөрийн хараат болон охин компанийд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:
- 5.4.1 Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ-өөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж

- болов бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 5.4.2 Компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 5.4.3 ТУЗ-ийн хараат бус бүх гишүүн тухайн хэлцэл хийхэд Сонирхлын зөрчил бүхий этгээдэд тооцогдсон.
- 5.5 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай Компанийн ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн олонхын саналаар гаргана.
- 5.6 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэхүү Журмын 5.4-т заасны дагуу батлуулах шаардлагагүй.
- 5.7 Сонирхлын зөрчил бүхий этгээдээр тооцогдохоос өмнө Компанийн буюу түүний охин, эсхүл хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан Сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл энэ Журмын 5.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.
- 5.8 Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх өдөр Компанийн буюу түүний охин, эсхүл хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран Компанийн буюу түүний охин, эсхүл хараат компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд Журмын 5.4-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

ЗУРГАА. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛД ТООЦОГДОХГҮЙ НӨХЦӨЛ

- 6.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд дараах тохиолдол үл хамаарна.
- 6.1.1 Компани нь охин компанийн бүх энгийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд Компанийн ТУЗ, эсхүл ТУЗ-өөс эрх олгосон этгээд охин компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа;
- 6.1.2 Компанийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх;
- 6.1.3 Компани нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авах;

6.1.4 Компани нь охин компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшидэг бол Монгол Улсын Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу охин компанийг өөртөө нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах.

ДОЛОО. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ

7.1 Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно.

7.1.1 Компанийн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

7.1.2 Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

7.2 Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн ТУЗ тогтооно.

7.3 Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь тухайн жилд сонгогдсон хараат бус аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляциын /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

7.4 Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг Компанийн ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100 хувь санал нэгтгэйгээр гаргана. Компанийн ТУЗ-өөс их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд уг асуудлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

НАЙМ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

8.1 Компани нь өөрийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүн зэрэг хэлцлийн талаарх мэдээллийг тухай бүр Компанийн “Мэдээллийн ил тод байдлын тухай журам”-д заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж, Компанийн цахим хуудас болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулна.

8.2 Компани нь тайлант хугацаанд өөрийн байгуулсан нийт их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүн зэрэг хэлцлийн талаарх мэдээллийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгана.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх бөгөөд Компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
- 9.2 Сонирхлын зөрчил бүхий этгээд нь энэхүү Журмын шаардлагыг зөрчсөний улмаас Компани буюу түүний хараат болон охин компанийд учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлэнэ.
- 9.3 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон Компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан журмын 8.2-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

АРАВ. БУСАД

- 10.1 Энэхүү Журам нь Компанийн ТҮЗ баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 10.2 Энэхүү Журмыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх гагцхүү Компанийн ТҮЗ-д хадгалагдана.
- 10.3 Энэхүү Журмын хэрэгжилтэд Компанийн ТҮЗ хяналт тавьж ажиллана.
- 10.4 Энэхүү Журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.
- 10.5 Энэхүү журамд иш татсан хууль тогтоомжийн аливаа зохицуулалтад өөрчлөлт орсноор холбогдох зүйл, хэсэг, заалтууд өөрчлөгдсөн нь энэхүү Журмын тухайн зохицуулалт хүчингүй болох үндэслэл болохгүй.

-ЛЭНДМН ББСБ ХК-

“ЛэндМН ББСБ” ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ын Хавсралт № 1

“СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЭТГЭЭДИЙН МАЯГТ”

“ЛЭНДМИН ББСБ” ХК (цаашид “Компани”)-тай зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх бүхий албан тушаалтан (*ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, энгийн хувьцааны 20-оос дээши хувийг эзэмшигч*) овогтой – ын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт.

Миний бие Монгол Улсын Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1 дэх хэсэгт заасныг үндэслэн өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2, 91 дүгээр зүйлийн 91.1 болон 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт зааснаар хүргүүлж байна. Үүнд (*1-б дээр тухайн хүн/хүмүүсийн овог, нэр; 7, 8 дээр хуулийн этгээдийн нэр болон 1-б-д дурдсан хүмүүсээс хэн нь хэдэн хувийг эзэмшидэгийг бичнэ*):

1. Эхнэр/нөхөр:
2. Хүү/охин:
3. Ач, зээ:
4. Аав/ээж:
5. Ах, эгч, дүү:
6. Бусад төрөл, садангийн хүн:
7. Миний бие болон дээр дурдсан хүн/ хүмүүсийн хяналтын багцыг эзэмшдэг хуулийн этгээд:
.....
.....
8. Миний бие болон дээр дурдсан хүн/хүмүүсийн албан тушаал:
.....
.....

Цаашид надтай нэгдмэл сонирхолтой дээрх хүмүүс, хуулийн этгээд болон түүний охин компанийтай гэрээ хэлцэл хийх тохиолдолд тухай бүр Компанийн ТУЗ-д мэдээлж байх болно.

Гарын үсэг.....

Огноо: 20... оны сарын өдөр